



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан





ЦАГААН САР 2025

ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА



Ийн бүр уламжлаа болгон зохион байгуулагдаг “Цагаан сар—2025” үзэсгэлэн худалдаа 2025 оны 02 сарын 17, 18-ны өдрүүдэд Улаангом хотод “Бөхийн өргөө”-нд зохион байгуулагдах тул орон нутгийн үйлдвэрээ эрхлэгчид өргөмөөр оролцоно уу.



Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг журамд заасны дагуу бүрдүүлсэн ч зээлийн зарцуулалтын үр дүн хангалтгүй, хяналтыг 4 сум бүрэн хэрэгжүүлээгүй байна.

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	Товчилсон үгийн тайлал	4
Аудитын менежер М.Бат-Амгалан	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
Ахлах аудитор Б.Авирмэд	Бүлэг А. Журамд заасан шалгуурыг хангаагүй бүрдэл дутуу баримтыг үндэслэн төслийг сонгон шалгаруулж сангийн хөрөнгөөс 8 хоршоонд 183.0 сая санхүүжилт олгосноос зээл эргэн төлөгдөхгүй байх эрсдэлийг дагуулж байна.	7
Аудитор Р.Аюуш	<i>А.1. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрийг журамд заасны дагуу бүрдүүлсэн байна.</i>	7
А.Нанжидмаа	<i>А.2. Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын зөвлөлийг журамд заасны дагуу байгуулсан байна.</i>	8
Л.Шагдарсүрэн	<i>А.3. Тэс, Завхан сумын Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хороо нь журамд заасан шаардлага бүрэн хангаагүй төслийг сонгон шалгаруулсан байна.</i>	9
	Бүлэг Б. Хор Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтын үр дүн хангалтгүй, 2.3 сая төгрөгийн зориулалтын бус зардал гаргасан байна.	11
	<i>Б.1. Хоршоо хөгжүүлэх сангаас авсан зээлийг 3 зээлдэгч зориулалтын дагуу дагуу зарцуулаагүй, Давст, Түргэн сум сангаас зориулалт бус зардал гаргасан байна.</i>	11
2026 оны 06 дугаар сар	<i>Б.2. Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан хоршоо, иргэд ажлын байрыг нэмэгдүүлсэн ч нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажаагүй байна.</i>	13
	<i>Б.3. Хоршоо хөгжүүлэх сангаас авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд төвлөрүүлээгүйгээс зээлийн үр дүн буурч байна.</i>	14
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг В. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн зарцуулалтад хяналтыг 4 сум үр дүнтэй хэрэгжүүлээгүй, мэдээ тайланг журамд заасан хугацаанд гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн байна.	18
	<i>В.1. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд 4 сумын хяналтын зөвлөл хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн байна.</i>	18
	<i>В.2. Сангийн орлого, зарлагын тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлж үйл ажиллагааны тайлангаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлсэн байна.</i>	18
	<i>В.3. Мэдээллийн ил тод байдлыг 4 сумаас бусад нь хангаж ажилласан, сумд зээлдэгчийн мэдээллийн санг бүрдүүлсэн байна.</i>	20
Хаяг: Увс аймаг дахь Төрийн аудитын газар Улаангом сум 3 дугаар баг, аймгийн Засаг даргын тамгын газрын байр	Дүгнэлт	22
	Холбогдох байгууллагын санал	23
	Аудитын газраас өгөх тайлбар	27
	Зөвлөмж	28
	Хавсралт	30

Товчилсон үгийн тайлал:

УВА	Увс аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/179 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Хоршоо хөгжүүлэх сангийн 2024-2025 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ Үүнд:

- Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу бүрдүүлж, шаардлага хангасан төслийг сонгон шалгаруулсан эсэх;
- Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх;
- Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн зарцуулалтад хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, мэдээ тайланг журамд заасан хугацаанд гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн эсэх;

Хамарсан хүрээ

Аудитад тухайн үед мөрдөгдөж байсан Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын хүрээнд 2024-2025 онуудад олгосон зээл болон эргэн төлөлтийн баримт, аймаг, сумдын Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газар, хороо болон хяналтын зөвлөл, Хоршоо хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтний зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажлын тайлан, холбогдох бусад баримт материалыг хамрууллаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглав.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг хангуулан, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Авирмэд, аудитор Р.Аюуш, А.Нанжидмаа, Л.Шагдарсүрэн нар хийж гүйцэтгэлээ.

Аудит эхлэхэд аудитор А.Нанжидмаа хүүхэд асрах чөлөөтэй байсан ба 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн аудитын гүйцэтгэлийн шатнаас аудитын багт орж ажилласан. Монгол Улсын Ерөнхий аудитораас 2026 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 1421 дүгээр албан бичгээр ирүүлсэн чиглэл, 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/73 дугаар тушаалын дагуу аудитор Р.Аюуш, Л.Шагдарсүрэн нар 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс нэмэлт аудит хийх болсон тул тайлагналын үе шатны ажлыг ахлах аудитор Б.Авирмэд, аудитор А.Нанжидмаа нар хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий зүйл

Увс аймгийн хувьд 2025 оны жилийн эцсийн байдлаар Хоршоо хөгжүүлэх сангаас 280 иргэн, аж ахуй нэгж, хоршоонд 4,562.9 сая төгрөгийн зээлийг олгосноос эцсийн үлдэгдэл 3,159.9 сая төгрөг байна.

Үүнээс 92 зээлдэгчийн 1,456.6 сая төгрөгийн зээл хэвийн, 17 зээлдэгчийн 215.9 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 7 зээлдэгчийн 97.3 сая төгрөгийн зээл хэвийн бус, 15 зээлдэгчийн 185.9 сая төгрөгийн зээл эргэлзээтэй, 149 зээлдэгчийн 1,204.2 сая төгрөгийн зээл муу ангилалтай байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас 2024 онд 17 хоршоонд 524.0 сая, 2025 онд 15 хоршоонд 647.1 сая, нийт 32 хоршоонд 1,171.1 сая төгрөгийн зээлийг шинээр олгосон байна.

Аудитын хамрах хугацаанд Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын журам хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан болно.

БҮЛЭГ: А. Журамд заасан шалгуурыг хангаагүй бүрдэл дутуу баримтыг үндэслэн төслийг сонгон шалгаруулж сангийн хөрөнгөөс 8 хоршоонд 183.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь зээл эргэн төлөгдөхгүй байх эрсдэлийг дагуулж байна.

А.1. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрийг журамд заасны дагуу бүрдүүлсэн байна.

Тухайн үед мөрдөгдөж байсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 2.1-д “Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ” гэж заасан байна. Үүнд:

- 2.1.1. Улсын болон орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;
- 2.1.2. Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив;
- 2.1.3. Сум хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөр;
- 2.1.4. Сангаас аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөр;
- 2.1.5. Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги;
- 2.1.6. Бусад;

Улсын төсвөөс 2011-2014 онд сумдын Хоршоо хөгжүүлэх санд 4,229.0 сая төгрөгийг олгосноор Хоршоо хөгжүүлэх сангийн анхны эх үүсвэр бүрдсэн байна.

Хүснэгт-1					/мян.төг/
№	Сумын нэр	2011 он	2013 он	2014 он	Нийт
1	Баруунтуруун	50,000.0	100,000.0	18,000.0	168,000.0
2	Бөхмөрөн	50,000.0	100,000.0	18,000.0	168,000.0
3	Давст	50,000.0	100,000.0	18,000.0	168,000.0
4	Завхан	50,000.0	100,000.0	18,000.0	168,000.0
5	Зүүнговь	50,000.0	100,000.0	35,000.1	185,000.1
6	Зүүнхангай	50,000.0	100,000.0	25,000.0	175,000.0
7	Малчин	50,000.0	100,000.0	24,000.0	174,000.0
8	Наранбулаг	60,000.0	120,000.0	36,000.8	216,000.8
9	Өлгий	50,000.0	100,000.0	18,000.0	168,000.0
10	Өмнөговь	60,000.0	120,000.0	24,000.0	204,000.0
11	Өндөрхангай	60,000.0	120,000.0	25,000.0	205,000.0
12	Сагил	50,000.0	100,000.0	18,000.0	168,000.0
13	Тариалан	60,000.0	120,000.0	24,000.0	204,000.0
14	Түргэн	50,000.0	100,000.0	18,000.0	168,000.0
15	Тэс	75,000.0	150,000.0	40,000.0	265,000.0
16	Ховд	50,000.0	100,000.0	28,000.0	178,000.0
17	Хяргас	50,000.0	100,000.0	28,000.0	178,000.0
18	Цагаанхайрхан	50,000.0	100,000.0	18,000.0	168,000.0
19	Улаангом	265,000.0	530,000.0	106,000.0	901,000.0
Нийт		1,230,000.0	2,460,000.0	539,000.9	4,229,000.9

Эх сурвалж: Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар

Сумдын хоршоо хөгжүүлэх сангийн эргэлтийн хөрөнгийн дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-2		/мян.төг/		
№	Сумдын нэр	Авлага	Мөнгөн хөрөнгө	Эргэлтийн хөрөнгийн дүн
1	Баруунтуруун	109,051.0	102,944.8	211,995.8
2	Бөхмөрөн	126,637.9	89,053.4	215,691.3
3	Давст	75,701.0	126,145.9	201,846.9
4	Завхан	151,289.1	66,000.3	217,289.4
5	Зүүнговь	86,013.8	122,683.3	208,697.1
6	Зүүнхангай	126,708.9	79,475.2	206,184.1
7	Малчин	153,129.3	63,930.9	217,060.2
8	Наранбулаг	124,022.8	145,569.5	269,592.3
9	Өлгий	78,654.7	133,383.9	212,038.6
10	Өмнөговь	115,055.8	137,991.1	253,046.9
11	Өндөрхангай	179,527.9	103,141.1	282,669.0
12	Сагил	55,670.9	125,509.7	181,180.6
13	Тариалан	196,779.9	123,635.8	320,415.7
14	Түргэн	110,457.2	92,776.5	203,233.7
15	Тэс	239,485.7	60,658.8	300,144.5
16	Улаангом	597,164.3	424,496.8	1,021,661.1
17	Ховд	230,596.2	3,424.2	234,020.4
18	Хяргас	221,503.2	30,593.2	252,096.4
19	Цагаанхайрхан	182,513.0	30,293.1	212,806.1
Нийт дүн		3,159,962.6	2,061,707.5	5,221,670.1

Эх сурвалж: Сумдын 2025 оны санхүүгийн тайлан, ХХС-ийн зээлийн мэдээллийн сангийн программ

Судалгаанаас харахад 2011 оноос хойш сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэр 5,221.7 сая төгрөг болж анх хуваарилснаас 992.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Сангаас аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөр, зээлийн хүү, хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүнд ногдуулсан алдангийн орлогоор сангийн эх үүсвэр нэмэгдсэн байна.

Харин гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив болон бусад эх үүсвэрээс санд хөрөнгө төвлөрөөгүй байна.

А.2. Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын зөвлөлийг журамд заасны дагуу байгуулсан байна.

Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 3.3-д “Сангийн үйл ажиллагааны талаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 3.3.2-т “Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах хороо болон хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг тус тус байгуулах” гэж заасны дагуу төсөл сонгон шалгаруулах хороо болон хяналтын зөвлөлийг 2024, 2025 онд сумдын ИТХ-ын шийдвэрээр шинэчлэн байгуулсан байна.

Тус журмын 4.1-д “Хороо болон хяналтын зөвлөл тус бүр нь дарга, гишүүд, нарийн бичгийн даргаас бүрдсэн таван хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд зөвлөлийн нарийн бичгийн даргаас бусад гишүүдийг давхардуулан ажиллуулахгүй”, 4.2-т “Хорооны даргаар тухайн сумын Засаг даргын Тамгын газрын дарга, гишүүдээр Санхүү, төрийн сангийн төлөөлөл, хоршоо, ЖДҮҮЭ-ийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан хоёр төрийн бус байгууллагын төлөөлөл байх бөгөөд нарийн бичгийн даргаар сумын хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна”, 4.3-д “Хяналтын зөвлөлийн даргаар тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

төлөөлөгч, гишүүдээр санхүү, төрийн сангийн мэргэжилтэн, аймгийн хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, төрийн бус байгууллагын төлөөлөл байх бөгөөд нарийн бичгийн даргаар сумын хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна” гэж заасны дагуу хороо болон хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 19 сумын ИТХ-аас томилсон байна.

А.3. Тэс, Завхан сумын Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хороо нь журамд заасан шаардлага бүрэн хангаагүй төслийг сонгон шалгаруулсан байна.

Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 5.5-д “Хоршоо нь төсөлд 15 төрлийн баримт материалуудыг хавсаргасан байна” гэж заажээ.

Сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх хоршоо нь журмын 6.3-д заасан 5 шаардлагыг хангасан байх ба сумын Засаг дарга нь зээлдэгчийн талаарх 11 баримт бичгийг эх хувиар нь баримтжуулан хадгалах үүргийг журмын 6.10-д заасны дагуу хүлээсэн байна. 2024-2025 онд сангийн хөрөнгөөр төсөл хэрэгжүүлэх, зээлдэгчдийн бүрдүүлэх материал, төсөлд тавигдах шаардлагыг дээрх заалт тус бүрээр үнэлэн үзэхэд Тэс, Завхан сум холбогдох баримт материалын бүрдэл дутуу төсөлд зээл олгосон байна.

Баримт материалын иж бүрдлийг сум тус бүрээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-3

№	Сумын нэр	2024 он		2025 он	
		Шалгар-сан төслийн тоо	Материал дутуу төсөл	Шалгар-сан төслийн тоо	Материал дутуу төсөл
1	Баруунтуруун	1	-	-	-
2	Бөхмөрөн	-	-	-	-
3	Давст	-	-	-	-
4	Завхан	-	-	1	1
5	Зүүнговь	-	-	-	-
6	Зүүнхангай	1	-	-	-
7	Малчин	1	-	1	-
8	Наранбулаг	-	-	1	-
9	Өлгий	1	-	-	-
10	Өмнөговь	3	-	-	-
11	Өндөрхангай	-	-	1	-
12	Сагил	-	-	-	-
13	Тариалан	2	-	1	-
14	Түргэн	1	-	1	-
15	Тэс	5	5	2	2
16	Улаангом	-	-	1	-
17	Цагаанхайрхан	-	-	4	-
18	Ховд	2	-	1	-
19	Хяргас	-	-	1	-
ДҮН		17	5	15	3

Эх сурвалж: Сумдын төслийн материал

Дээрх судалгаанаас харахад Тэс сум 2024 онд 5 зээлдэгчид 103.0 сая, 2025 онд 2 зээлдэгчид 20.0 сая, Завхан сум 2025 онд 1 зээлдэгчид 60.0 сая төгрөгийн зээлийг материалын бүрдэл дутуу төсөлд олгосон байна.

Цаашид журамд заасан шалгуурыг баримталж, шаардлага бүрэн хангасан төсөлд зээл олгож байх зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өглөө.

Мөн Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 6.10-т “Сумын Засаг дарга зээлдэгчийн талаарх дараах баримт бичгийг эх хувиар нь баримтжуулан хадгална”, 6.10.7-д “барьцаа хөрөнгийн үнэлгээний жагсаалт, барьцаалсан үнэ, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээний эх хувь болон барьцаа хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж барьцаалбар үйлдсэн тухай баримтыг хавсаргана” гэж заасныг зөрчиж Тэс сум 2024 онд 5 хоршоонд 103.0 сая, 2025 онд 2 хоршоонд 20.0 сая, Түргэн сум Буурал шүтээн хоршоонд 2024 онд 30.0 сая, Баянцагаан суварга хоршоонд 2025 онд 10.0 сая, Тариалан сум Эко арга билэг хоршоонд 2025 онд 70.0 сая, Малчин сум Баян-Эрдэнэ сүрэг хоршоонд 2024 онд 50.0 сая, Увс хар азарга хоршоонд 2025 онд 14.0 сая төгрөгийн зээлийг барьцаа хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлж барьцаалбар үйлдээгүй байхад олгосон байна.

Үүнээс шалтгаалан тухайн зээлдэгчид зээлээ төлөөгүй тохиолдолд барьцаа хөрөнгийг худалдан борлуулж зээлийг барагдуулах нөхцөл бүрэн бүрдэхгүй байх эрсдэл учирч болзошгүй байна.

Иймд дээрх зээлдэгч нартай байгуулсан барьцааны гэрээнд заасны дагуу барьцаалбар үйлдүүлж зээлийн хувийн хэрэгт хавсаргах зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өглөө.

БҮЛЭГ: Б. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтын үр дүн хангалтгүй, 2.3 сая төгрөгийн зориулалт бус зардал гаргасан байна.

Б.1. Хоршоо хөгжүүлэх сангаас авсан зээлийг 3 зээлдэгч зориулалтын дагуу зарцуулаагүй, Давст, Түргэн сум сангаас зориулалт бус зардал гаргасан байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас 2024-2025 онд олгосон зээлийн мэдээллийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-4		/мян.төг/			
№	Сумдын нэр	2024 он		2025 он	
		Тоо	Олгосон зээл	Тоо	Олгосон зээл
1	Баруунтуруун	1	36,000.0	-	-
2	Бөхмөрөн	-	-	-	-
3	Давст	-	-	-	-
4	Завхан	-	-	1	60,000.0
5	Зүүнговь	-	-	-	-
6	Зүүнхангай	1	25,000.0	-	-
7	Малчин	1	50,000.0	1	14,000.0
8	Наранбулаг	-	-	1	30,000.0
9	Өлгий	1	35,000.0	0	0
10	Өмнөговь	3	75,000.0	0	0
11	Өндөрхангай	-	-	1	60,000.0
12	Сагил	-	-	-	-
13	Тариалан	2	100,000.0	1	70,000.0
14	Түргэн	1	30,000.0	1	10,000.0
15	Тэс	5	103,000.0	2	20,000.0
16	Улаангом			1	60,000.0
17	Ховд	-	-	4	173,074.4
18	Хяргас	2	70,000.0	1	50,000.0
19	Цагаанхайрхан	-	-	1	100,000.0
Нийт дүн		17	524,000.0	15	647,074.4

Эх сурвалж: Сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн анхан шатны баримт

Судалгаанаас харахад Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөс 2024 онд 17 зээлдэгчид 524.0 сая, 2025 онд 15 зээлдэгчид 647.1 сая, нийт 32 зээлдэгчид 1,171.1 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 11.1-д “Сангаас зээл авсан этгээд зээлийг үр ашиггүй зарцуулсан буюу зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн этгээдэд олгосон хөнгөлөлттэй зээлийг буцаан төвлөрүүлэх бөгөөд сангаас дахин зээл олгохгүй” гэж заасан байна.

Аудитын явцад түүврээр 9 сумын 12 зээлдэгчдийн хэрэгжүүлж байгаа төсөлтэй газар дээр нь танилцаж хяналт хийхэд Хяргас сумын 1, Өлгий сумын 1, Өндөрхангай сумын 1, нийт 3 зээлдэгчтэй холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Хүснэгт-5

№	Сумын нэр	Зээл олгосон огноо	Зээлийн дүн /мян.төг/	Зээлдэгчийн нэр	Зээлийн зориулалт	Тайлбар
1	Өндөрхангай	2025	60,000.0	Шимтэй Увс	Сав баглаа боодол	Зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй
2	Өлгий	2024	35,000.0	Ашиг шимт Өлгийн улаан	Сүү, цагаан идээ боловсруулалт	
3	Хяргас	2024	35,000.0	Ган мядаг	Түүхий эд боловсруулалт	
Дүн			130,000.0			

Журмын 7.3-д “Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгах бөгөөд хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бусаар зарцуулсан, зээлийн гэрээнд заасан заалтыг зөрчсөн зээлдэгчийн зээлийн гэрээг цуцалж, зээлийг сангийн дансанд буцаан төвлөрүүлэх ажиллагааг зохион байгуулах” гэж заасныг мөрдөж дээрх 3 зээлийн гэрээг цуцалж зээлийн төлөгдөөгүй байгаа үлдэгдлийг сангийн дансанд төвлөрүүлэх зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд өглөө.

Журмын 2.7-д “Сангаас олгосон зээлийн хүүгийн өмнөх жилийн орлогын 30 хүртэл хувийг хоршоонд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хүртэл хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаа болон программ хангамжийн зардалд, 10 хүртэл хувийг аймгийн жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилт хариуцсан байгууллагын саналыг харгалзан сумын хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтнийг урамшуулахад зориулан хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулж болно” гэж заасныг Тэс, Бөхмөрөн, Давст сум зөрчиж ИТХ-аар батлуулсан байна. Үүнд:

- Бөхмөрөн сум хүүгийн орлогыг журамд заасан хэмжээнээс 2024 онд 1.9 сая, 2025 онд 1.8 сая, нийт 3.7 сая төгрөгөөр хэтрүүлэн батлуулсан.
- Давст сум 2025 онд хүүгийн орлогыг журамд заасан хэмжээнээс 2025 онд 2.0 сая төгрөгөөр хэтрүүлэн батлуулсан.
- Тэс сум хүүгийн орлогыг журамд заасан хэмжээнээс 2024 онд 0.2 сая, 2025 онд 0.2 сая, нийт 0.4 сая төгрөгөөр хэтрүүлэн батлуулсан.

Цаашид Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг журамд заасан хэмжээнээс хэтрүүлэн батлуулахгүй байх зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өглөө.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 1.4-т “Сангийн орлого, зарлага нь сумын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, улирал, жилийн тайлан тэнцэлд тусгагдана” гэж заасныг зөрчин Өлгий сум 2024 оны санхүүгийн тайланд 0.1 сая төгрөгийн данс андуурсан гүйлгээг залруулаагүй, орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан, Наранбулаг сум 2025 оны санхүүгийн тайланд 2.2 сая төгрөгөөр авлагыг илүү бууруулсан байна.

Цаашид санхүүгийн тайланг хууль журамд заасны дагуу үнэн зөв тайлагнаж байх зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өглөө.

Журмын 1.5-д “Сангийн хөрөнгө нь суманд хоршоо санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, сургалт зохион байгуулах, хяналт тавих, авлага барагдуулах, урамшуулал олгоход зориулагдана”, 2.8-д “Энэхүү журмын 1.5, 2.7-д зааснаас бусад зориулалтаар

сангийн хөрөнгийг сумын төсвийн алдагдал нөхөх, төсөвт байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх, байгалийн гамшгаас учирсан хохирлыг нөхөн төлөх зэргээр зарцуулахыг хориглоно” гэж заасныг зөрчин Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны зардлаас Давст сум 2024 онд 0.7 сая, 2025 онд 1.0 сая нийт 1.7 сая, Түргэн сум 2024 онд 0.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

Б.2. Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан хоршоо, иргэд ажлын байрыг нэмэгдүүлсэн ч нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажуагүй байна.

Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 5-д “Зээлд хамрагдах төсөлд тавигдах шаардлага”, 5.4.4-т “Шинээр бий болгох ажлын байрны тоо”, 6.4-т “Энэ журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан хоршооны боловсруулсан төсөл дараах нийтлэг шалгуурыг хангасан байна”, 6.4.6-д “ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх” гэж заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, хоршооны зээл авсан төслүүдэд ажлын байрыг нэмэгдүүлэх талаар тодорхой тусгасан байна. Тухайлбал: 2024 онд 53, 2025 онд 42, нийт 95 ажлын байр бий болгохоор төсөлд тусгасан байна.

Журмын 7.11-д “Хоршоо нь сумын иргэдийн хоршиж хөдөлмөрлөх идэвх санаачилгыг дэмжих, шинээр ажлын байр бий болгох, ажлын байрыг тогтвортой хадгалах, эрүүл, аюулгүй хүнс, үйлчилгээгээр хангах, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэх, орон нутгийн нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах үүрэг хүлээнэ” гэж заасан ч нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажсан ажлын байрны тоо хангалтгүй байна. Төсөлд тусгасан болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажсан ажлын байрны тоог хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-8

№	Сумын нэр	2024 он		2025 он	
		Төслөөр	НДШ төлөлтөөр	Төслөөр	НДШ төлөлтөөр
1	Баруунтуруун	6	2	-	-
2	Бөхмөрөн	-	-	-	-
3	Давст	-	-	-	-
4	Завхан	0	0	4	1
5	Зүүнговь	-	-	-	-
6	Зүүнхангай	2	2	-	-
7	Малчин	1	1	3	1
8	Наранбулаг	0	0	8	1
9	Өлгий	5	1	0	0
10	Өмнөговь	12	3	0	0
11	Өндөрхангай	-	-	2	1
12	Сагил	-	-	-	-
13	Тариалан	5	3	3	3
14	Түргэн	2	1	1	-
15	Тэс	16	2	4	-
16	Улаангом	-	-	5	1
17	Ховд	-	-	8	4
18	Хяргас	4	1	2	2
19	Цагаанхайрхан	-	-	2	2
Нийт дүн		53	16	42	16

Эх сурвалж: Төслийн баримт бичиг, НДШ төлсөн баримт

Судалгаанаас харахад 2024 онд төслөөр 53 ажлын байр бий болгохоор төлөвлөсөн ч НДШ төлөлтөөр 16 ажлын байр, 2025 онд төслөөр 42 ажлын байр бий болгохоор төлөвлөсөн ч НДШ төлөлтөөр 16 ажлын байр, нийт төслөөр 95 ажлын байр бий болгохоор төлөвлөсөн ч НДШ төлөлтөөр 32 ажлын байр бий болсон нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлдэгчдийн НДШ төлөлт хангалтгүй байгааг харуулж байна.

Төлөвлөснөөс НДШ төлөлтөөр баталгаажсан ажлын байр харьцангуй бага байгаа талаар холбогдох мэргэжилтнүүд болон зээлдэгчдээс тодруулж нэгтгэн дүгнэхэд дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:

- Зээл авсан иргэн, аж ахуйн нэгж хоршоо зээлээ зориулалтын дагуу ашиглаж үйл ажиллагаа явуулж өөртөө болон бусдад ажлын байр бий болгож байгаа боловч зардал өндөр гарч төслийн үр ашиг хангалтгүй байгаагаас шалтгаалан НДШ төлдөггүй,
- Зарим төслийн үйл ажиллагаа улирлын шинж чанартай байдгаас шалтгаалан байнгын ажлын байр бий болдоггүй. Тухайлбал: Газар тариалан, жимс жимсгэнэ, сүү цагаан идээ гэх мэт,
- Анх зээл авахдаа шаардлагад нийцүүлэхийн тулд бий болгох ажлын байрны тоог өндөр тавьдаг. Мөн зах зээлийн багтаамж, борлуулалтын орлогыг хэт өөдрөгөөр төсөөлж төсөлд тусгаж тэр хирээр ажлын байр бий болгохоор тооцдог ч хэрэгжүүлэх явцад нөхцөл байдал өөрчлөгддөг.

Цаашид төсөл хэрэгжүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, хоршооны төсөлд бодитоор бий болгох ажлын байрны тоог тусгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх талаар зөвлөмж чиглэл хүргүүлж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөлөө.

Б.3. Хоршоо хөгжүүлэх сангаас авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд төвлөрүүлээгүйгээс зээлийн үр дүн буурч байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үлдэгдлийг аймгийн дүнгээр 2024-2025 оны байдлаар өссөн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-9

/мян.төг/

Аудитад хамрагдсан 2024-2025 онуудад олгосон зээлээс муу зээл байхгүй бөгөөд 2025 оны 1,204.2 сая төгрөгийн муу зээл нь 2011 оноос эхлэн он дамжин хуримтлагдсан үлдэгдэл байна.

Увс аймаг		2024 он	2025 он	Зөрүү
Зээлийн эцсийн үлдэгдэл		3,520,056.5	3,159,056.9	(360,999.6)
Зээлдэгчийн тоо		329	280	(49)
Үүнээс	Хэвийн зээл	1,477,941.4	1,456,623.3	(21,318.1)
	Хугацаа хэтэрсэн зээл	273,057.7	215,966.9	(57,090.8)
	Хэвийн бус	304,202.4	97,332.6	(206,869.8)
	Эргэлзээтэй	433,272.7	185,862.5	(247,410.2)
	Муу	1,032,488.0	1,204,177.4	171,689.3

Эх сурвалж: ХХААГ, сумдаас ирүүлсэн судалгаа

Судалгаанаас харахад 2025 оны байдлаар 280 зээлдэгч 3,159.9 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаагаас хэвийн төлөлттэй зээл 46.1 хувь буюу 1,456.6 сая хугацаа хэтэрсэн зээл 6.9 хувь буюу 215.9 сая, хэвийн бус 3.0 хувь буюу 97.3 сая, эргэлзээтэй 5.9 хувь буюу 185.9 сая, муу 38.1 хувь буюу 1,204.2 сая төгрөг байгаа нь зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгааг харуулж байна. Үүнээс шалтгаалж зээлийн эргэлт удааширч, Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд нөлөөлөх эрсдэлийг бий болгож байна.

Сангийн хэвийн зээлийн төлөлт буурч, муу ангиллын зээл өссөн байгаа нь сумдын Засаг дарга нарын зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байгааг харуулж байна. Тухайлбал: Хэвийн зээлийн хэмжээ 2024 онд 1,477.9 сая төгрөг байсан бол 2025 онд 1,456.6 сая төгрөг болж 21.3 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан, муу зээлийн хэмжээ 1,204.2 сая төгрөгөөр буюу 16.6 хувиар өссөн байна.

Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ” гэж заасны дагуу хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулж ажиллах, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, Монгол банкны зээлийн мэдээллийн санд мэдээллийг нийлүүлэх зэрэг арга замаар чанаргүй зээлийн үлдэгдлийг барагдуулах зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өглөө.

Зүүнговь сумын Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авч төлөлт хийгээгүй иргэн Х.Анхбаяраас Шүүхийн шийдвэрээр 129 боодол өвс, иргэн Б.Нямдэлэгээс 325 боодол өвсийг хураан авсан ч худалдан борлуулж сангийн дансанд төвлөрүүлээгүй тул зээлийн өрийн үлдэгдлээс хасагдаагүй байна.

Тухайн зээлдэгч нарын зээлийн үлдэгдэл зөрүүтэй байгаа асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг Зүүнговь сумын Засаг даргад өглөө.

Тайлант онуудад Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын зүгээс эргэлзээтэй болон муу зээлүүдийг төлүүлэх 15 шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулахаар гүйцэтгэх ажиллагаа явуулсан байна. Үүнээс 3 зээлдэгчийн зээлийг бүрэн, 7 зээлдэгчийн зээлийг хэсэгчлэн төлүүлсэн ба төлбөрийн чадваргүй зээлдэгчийн дансыг битүүмжлэх, хаяг дээрээ амьдардаггүй зээлдэгчийг эрэн сурвалжлах зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Түүнчлэн нэхэмжлэгчийн хүсэлтээр шийдвэр гүйцэтгэлийн шатнаас буцаасан 17 зээлдэгчээс 5 зээлдэгч төлбөрөө бүрэн барагдуулж, 12 зээлдэгч үлдэгдэлтэй байна.

Мөн 7 зээлдэгчтэй холбоотой шүүхийн шийдвэр гарсан боловч нэхэмжлэгч нь хүсэлт гаргаагүйгээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь гүйцэтгэх ажиллагаа явуулаагүй байна.

Нэхэмжлэгчийн хүсэлтээр буцаасан ч зээлийн барагдаагүй үлдэгдэлтэй болон гүйцэтгэх хуудас бичигдээгүй зээлдэгчийн асуудлыг Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлэхийг зөвлөснөөр аудитын явцад холбогдох албан тушаалтнууд албан бичгээр хүргүүлэн ажиллаа.

Харин Улаангом сумын буцаасан 7 зээлдэгч болон өмнөх оны бүрэн барагдаагүй 15, нийт 22 зээлдэгчтэй холбоотой шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 131 дүгээр албан бичгийг Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлсэн байна.

Журмын 9.1-д “Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зээл авсан аж ахуйн нэгжийн холбогдох мэдээллийг агуулсан Зээлийн мэдээллийн нэгдсэн санг хөтөлнө” гэж заасны дагуу сумдын мэргэжилтнүүд зээлийн мэдээллээ нэгдсэн санд хөтөлж хэвшсэн байна. Харин Тэс

сумын мэргэжилтэн 2024-2025 онд зээлдэгчдийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд зөрүүтэй оруулсан байна.

Зээлийн мэдээллийн санд Тэс сумын 2024 онд зөрүүтэй оруулсан мэдээлэл

Хүснэгт-10				/мян.төг/				
№	Зээлдэгчийн нэр	Анх авсан зээл	Төлбөл зохих дүн	Төлсөн дүн		Эцсийн үлдэгдэл		Зөрүү
				Программ	Хуулга	Программ	Тулгалтаар	
1	Ядамцоо.З	2,000.0	2,115.2	718.0	618.0	-	100.0	100.0
2	Бат-Эрдэнэ.А	3,000.0	3,180.0	1,090.0	1,030.0	-	60.0	60.0
3	Дүүдээ.Б	4,000.0	4,255.0	1,545.0	1,535.0	-	10.0	10.0
4	Батсүх.Б	5,000.0	5,330.0	5,180.0	4,180.0	-	1,000.0	1,000.0
5	Бүзмээ.Я	3,000.0	3,281.4	420.0	419.0	2,771.1	2,772.1	1.0
6	Цэнджав.Ц	5,000.0	5,469.0	1,081.5	1,043.5	4,275.5	4,313.5	38.0
7	Хотгор Өлөн	10,000.0	10,938.0	1,700.0	1,300.0	8,937.9	9,337.9	400.0
Нийт дүн		32,000.0	34,568.6	11,734.5	10,125.5	15,984.5	17,593.5	1,609.0
1	Шар булаг	18,000.0	19,688.4	2,655.0	3,780.0	16,618.4	15,493.4	(1,125.0)
Нийт дүн		18,000.0	19,688.4	2,655.0	3,780.0	16,618.4	15,493.4	(1,125.0)

Эх сурвалж: Аудитын түүвэр, тулгалт

Хүснэгтээс харахад зээлийн мэдээллийн санд 2024 онд 1 зээлдэгчийн 1.1 сая төгрөгийг дутуу суутгаж, 7 зээлдэгчээс 1.6 сая төгрөгийг илүү суутгасан байна.

Зээлийн мэдээллийн санд Тэс сумын 2025 онд зөрүүтэй оруулсан мэдээлэл

Хүснэгт-11				/мян.төг/				
№	Зээлдэгчийн нэр	Анх авсан зээл	Төлбөл зохих дүн	Төлсөн дүн		Эцсийн үлдэгдэл		Зөрүү
				Программ	Хуулга	Программ	Тулгалт	
1	Мунтаа.Ө	3,000.0	3,180.0	940.0	-	-	940.0	940.0
2	Хүрэлхүү.С	5,000.0	6,061.5	2,400.0	-	3,511.5	5,911.5	2,400.0
3	Янжмаа.Н	4,000.0	4,971.3	4,851.3	-	-	4,851.3	4,851.3
4	Баяраа.Н	4,000.0	4,375.2	552.0	-	3,703.2	4,255.2	552.0
5	Бямбацогт.П	7,000.0	7,656.6	2,900.0	-	4,704.8	7,604.8	2,900.0
6	Хувьзаяа .П	3,000.0	3,281.4	1,440.7	204.0	1,750.7	2,987.4	1,236.7
7	Оргил .Б	5,000.0	5,469.0	2,055.2	1,348.4	2,917.8	3,624.6	706.8
8	Ичинхорлоо.Ц	4,000.0	4,375.2	1,457.6	1,117.7	2,517.3	2,857.2	339.8
9	Шар булаг	18,000.0	19,688.4	6,220.0	6,160.0	10,398.4	10,458.4	60.0
10	Цэвэлмаа .Б	3,000.0	3,281.4	1,640.9	1,030.9	1,550.5	2,160.5	610.0
11	Батхүү .Н	3,000.0	3,281.4	1,233.0	408.0	1,748.4	2,573.4	825.0
12	Чимэд .Т	5,000.0	5,469.0	2,514.2	1,704.0	2,917.8	3,728.0	810.2
13	Хар гурви	23,000.0	25,155.9	344.0	-	24,638.9	24,982.9	344.0
14	Хулхын ам	15,000.0	16,406.0	450.0	230.0	15,956.0	16,176.0	220.0
15	Шар хөдөө	20,000.0	21,874.7	1,999.6	1,848.6	19,875.1	20,026.1	151.0
16	Билэг биг бейкери	10,000.0	10,910.6	272.9	272.5	10,637.7	10,638.1	0.4
17	Ирээдүй түвшин нандин зул	10,000.0	11,237.6	224.4	222.0	11,013.2	11,015.6	2.4
18	Товшоон цагаан	20,000.0	21,800.7	3,093.8	-	18,706.8	21,800.7	3,093.8
Нийт дүн		162,000.0	178,475.9	34,589.5	14,546.1	136,548.2	156,591.6	20,043.4

1	Насанжаргал.Д	3,000.0	3,180.0	1,090.0	2,000.0	2,000.0	1,090.0	(910.0)
2	Бат-Эрдэнэ .Г	3,000.0	3,281.4	609.0	807.0	1,748.3	1,550.3	(198.0)
3	Жигдэн.Д	5,000.0	5,469.0	3,932.6	3,933.0	-	(0.4)	(0.4)
4	Тэсийн шугуйн цуурай	25,000.0	27,343.4	561.0	700.0	26,782.4	26,643.4	(139.0)
Нийт дүн		36,000.0	39,273.8	6,192.6	7,440.0	30,530.7	29,283.3	(1,247.4)

Эх сурвалж: Аудитын түүвэр, тулгалт

Хүснэгтээс харахад 2025 онд 4 зээлдэгчийн 1.2 сая төгрөгийг дутуу суутгаж, 18 зээлдэгчээс 20.0 сая төгрөгийг илүү суутгасан байна.

Журмын 7.3-д “Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгах бөгөөд хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бусаар зарцуулсан, зээлийн гэрээнд заасан заалтыг зөрчсөн зээлдэгчийн зээлийн гэрээг цуцалж, зээлийг сангийн дансанд буцаан төвлөрүүлэх ажиллагааг зохион байгуулах” гэж заасныг хэрэгжүүлэн дээрх зээлдэгч нарын мэдээллийг зээлийн мэдээллийн санд үнэн зөвөөр оруулж үүссэн зөрчлийг арилгах зөвлөмжийг Тэс сумын Засаг даргад өглөө.

Тэс сумын мэргэжилтэн нь 2024-2025 онд олгосон 123.0 сая төгрөгийн 7 зээлд барьцаалбар үйлдээгүй, зээл авсан хоршооны нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжих байршил, сонгон шалгаруулсан шийдвэрийг цахим хуудсаараа дамжуулан нийтэд ил тод мэдээлээгүй, албан үүргээ биелүүлээгүй, зээлдэгч нарын мэдээллийг зээлийн мэдээллийн санд зөрүүтэй оруулсан зэрэг зөрчлүүдийг үндэслэн хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

БҮЛЭГ:В. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн зарцуулалтад хяналтыг 4 сум үр дүнтэй хэрэгжүүлээгүй, сумд мэдээ тайланг журамд заасан хугацаанд гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн байна.

В.1. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд 4 сумын хяналтын зөвлөл хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 7.4-д "Хяналтын зөвлөл сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавихдаа дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ", 7.4.2-т "Сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад хүргүүлнэ" гэж заажээ.

Сумдын хяналтын зөвлөл нь хяналт хийсэн байдлыг харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-12

№	Сумдын нэр	Хяналтын тоо	
		2024 он	2025 он
1	Баруунтуруун	1	1
2	Бөхмөрөн	0	1
3	Давст	1	1
4	Завхан	2	2
5	Зүүнговь	1	1
6	Зүүнхангай	1	2
7	Малчин	1	1
8	Наранбулаг	2	2
9	Өлгий	2	2
10	Өмнөговь	2	2
11	Өндөрхангай	4	3
12	Сагил	2	2
13	Тариалан	0	1
14	Түргэн	1	1
15	Тэс	1	1
16	Улаангом	1	4
17	Ховд	0	0
18	Хяргас	2	2
19	Цагаанхайрхан	0	1

Эх сурвалж: Хяналтын зөвлөлийн тайлан хурлын тэмдэглэл

Дээрх мэдээллээс харахад сумдын хяналтын зөвлөл нь сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг харилцан адилгүй хийдэг, зарим жилд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Бөхмөрөн, Тариалан, Цагаанхайрхан сумын хяналтын зөвлөл 2024 онд, Ховд сумын хяналтын зөвлөл 2024, 2025 онд сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавиагүй байна.

Бөхмөрөн, Тариалан, Цагаанхайрхан, Ховд сумдын хяналтын зөвлөлд хяналт шалгалтыг журамд заасны дагуу хийж байх зөвлөмж өглөө.

В.2. Сангийн орлого, зарлагын тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлж, үйл ажиллагааны тайлангаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлсэн байна.

Аудитад хамрагдсан 2024-2025 онд сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын зөвлөлийг байгуулж, төслийн сонгон шалгаруулах тов тогтоох, зээл олгох тэргүүлэх чиглэл батлуулж, сангаас тухайн жилд олгох зээлийн дээд хэмжээг тогтоож ажилласан байна.

Журмын 3.4-т “Сангийн үйл ажиллагааны талаар сумын Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 3.4.6-д “Сангийн орлого, зарлагыг хөтлөх үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг мөрдүүлж, сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд тухайн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах” гэж заасны дагуу сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг тухайн шатны ИТХ-д тайлагнасан байна.

Сангийн үйл ажиллагааг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж мэдээллээр хангасан байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-13

№	Сумдын нэр	2024 он	2025 он
1	Баруунтуруун	тийм	тийм
2	Бөхмөрөн	тийм	тийм
3	Давст	тийм	тийм
4	Завхан	тийм	тийм
5	Зүүнговь	тийм	тийм
6	Зүүнхангай	тийм	тийм
7	Малчин	тийм	тийм
8	Наранбулаг	тийм	тийм
9	Өлгий	тийм	тийм
10	Өмнөговь	тийм	тийм
11	Өндөрхангай	тийм	тийм
12	Сагил	тийм	тийм
13	Тариалан	тийм	тийм
14	Түргэн	тийм	тийм
15	Тэс	тийм	тийм
16	Улаангом	тийм	тийм
17	Ховд	тийм	тийм
18	Хяргас	тийм	тийм
19	Цагаанхайрхан	тийм	тийм

Хүснэгтээс харахад сумдын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил жилийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа танилцуулж хэвшсэн байна.

Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 7.5-д “Сумын Засаг дарга сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг улирал болон жилээр гаргаж, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор тухайн аймгийн Засаг даргад хүргүүлнэ” гэж заасны дагуу сумдын холбогдох мэргэжилтнүүд Хоршоог хөгжүүлэх сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг улирал болон жилээр гаргаж журамд заасан хугацаанд цахим болон цаасаар ХХААГ-т хүргүүлсэн байна.

Журмын 7.6-д “Аймгийн Засаг дарга энэ журмын 7.5-т заасан сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн улирлын болон жилийн тайланг нэгтгэн, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэж заасан байна.

Аймгийн Засаг дарга ХХААГ-аар дамжуулан журмын дагуу аймгийн Хоршоо хөгжүүлэх сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн улирлын болон жилийн тайланг нэгтгэн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн ажилласан байна.

В.3. Мэдээллийн ил тод байдлыг 4 сумаас бусад нь хангаж ажилласан, сумд зээлдэгчийн мэдээллийн санг бүрдүүлсэн байна.

Сумд 2024-2025 онд төсөл сонгон шалгаруулах тов, тавигдах шаардлага, төслийн чиглэлийг олон нийтийн цахим сүлжээ болон Засаг даргын Тамгын газрын нийтийн мэдээллийн самбарт байршуулсан байна.

Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 2.11-д "Төсөл хүлээн авах хугацааг тухайн сумын иргэдэд мэдэгдсэнээс хойш хуанлийн 30 хоногийн хугацаанд цахимаар эсхүл цаасан хэлбэрээр хүлээн авна" гэж заасан байхад Сагил сум 2024-2025 онд төсөл хүлээн авах хугацааг 15 хонгоор зарласан байна. Журамд заасан хугацааг 2 дахин багасгаж зарласнаас төсөлд хамрагдах боломжит хугацаа хязгаарлагдаж 2024-2025 онд Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгогдоогүй байна.

Сагил сумын Засаг даргад төсөл хүлээн авахдаа журамд заасан хугацааг баримталж ажиллах зөвлөмж өглөө.

Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 5.1-д "Сангийн үйл ажиллагаа нийтэд ил тод, нээлттэй байна. Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад тухайн сумын иргэд хяналт тавих бөгөөд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэж болно" гэж заасны дагуу сумд шилэн дансны цахим хуудсаар дамжуулан сангийн орлого зарлагыг нийтэд мэдээлсэн байна.

Журмын 8.2-т "Хорооны хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан шалгарсан хоршооны мэдээллийг аймаг, сумын Засаг дарга цахим хуудсаараа дамжуулан мэдээлнэ", 8.3-д "Зээл авсан Хоршооны нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжих байршил, сонгон шалгаруулсан шийдвэрийг Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу байгууллагын шилэн данс, цахим хуудсаараа дамжуулан нийтэд ил тод мэдээлнэ" гэж заасны дагуу 2024-2025 онд нийтэд мэдээлсэн байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-14

№	Сумдын нэр	2024 он		2025 он		Шаардлагагүй
		Мэдээлсэн	Мэдээлээгүй	Мэдээлсэн	Мэдээлээгүй	
1	Баруунтуруун	1				1
2	Бөхмөрөн	1		1		
3	Давст	1		1		
4	Завхан	1		0.5	0.5	
5	Зүүнговь	1		1		
6	Зүүнхангай	1		1		
7	Малчин	1		1		
8	Наранбулаг			0.5	0.5	1
9	Өлгий	1		1		
10	Өмнөговь	1		1		
11	Өндөрхангай	1		1		
12	Сагил	1		1		
13	Тариалан	1		1		
14	Түргэн	1		1		
15	Тэс	0.5	0.5	1		

16	Улаангом	1		1		
17	Ховд	1		1		
18	Хяргас	1		0.5	0.5	
19	Цагаанхайрхан			1		1
Нийт дүн		16.5	0.5	16.5	1.5	3

Эх сурвалж: 2024-2025 оны аудитын түүвэр

Дээрх хүснэгтээс харахад ил тод байдлыг ихэнх сумд ханган ажиллаж байгаа боловч 2024 онд Тэс сум, 2025 онд Завхан, Наранбулаг, Хяргас, сумд зээл авсан хоршооны нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжих байршил, сонгон шалгаруулсан шийдвэрийг ил тод мэдээлж ажиллаагүй байна.

Цаашид Тэс, Завхан, Наранбулаг, Хяргас, сумдын холбогдох албан тушаалтанд зээл авсан хоршооны нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжих байршил, сонгон шалгаруулсан шийдвэрийн мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлж ажиллах зөвлөмж өглөө.

Журмын 3.1.4-д “Сангаас олгосон зээлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн хөтөлж, холбогдох мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах” гэж заасны дагуу сангийн зээлийн үлдэгдлийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэж байна.

Аудитын хүрээнд зээлдэгчийн 2024-2025 оны зээлийн төлөлтийг дансны хуулгатай тулгалт хийж үүссэн зөрүүг арилган журмын 9.3-т “Зээлийн мэдээллийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд тогтмол нийлүүлнэ” гэж заасны дагуу мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд илгээлгэлээ.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлсэн байна.
2. Тэс, Завхан сум журамд заасан шалгуур, шаардлагыг бүрэн хангаагүй 183.0 сая төгрөгийн 8 төсөлд зээл олгосон нь зээл эргэн төлөгдөхгүй байх эрсдэлийг дагуулж байна.
3. Тэс сум 7 хоршоонд 123.0 сая, Түргэн сум 2 хоршоонд 40.0 сая, Тариалан сум 1 хоршоонд 70.0 сая, Малчин сум 2 хоршоонд 64.0 сая төгрөгийн зээлийг барьцаалбар үйлдээгүй байхад олгосон байна.
4. Хоршоо хөгжүүлэх сангаас авсан 130.0 сая төгрөгийн зээлийг 3 зээлдэгч зориулалтын дагуу зарцуулаагүй, Давст, Түргэн сум 2.3 сая төгрөгийн зориулалт бус зардал гаргасан нь зээлийн ач холбогдлыг бууруулж байна.
5. Тэс, Бөхмөрөн, Давст сум хүүгийн орлогоос журамд заасан зарцуулах хувь хэмжээнээс 6.1 сая төгрөгөөр хэтрүүлэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан байна.
6. Өлгий сум 2024 оны санхүүгийн тайланд 0.1 сая төгрөгийн данс андуурсан гүйлгээг орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан, Наранбулаг сум 2025 оны санхүүгийн тайланд 2.2 сая төгрөгийн авлагыг илүү бууруулсан байна.
7. Хоршоо хөгжүүлэх сангийн 2025 оны жилийн эцсээрх нийт зээлээс 1,204.2 сая төгрөг буюу 38.0 хувийг муу зээл эзэлж байгаа нь зээлийн эргэн төлөлт буурах, сангийн эх үүсвэр дутагдах эрсдэлтэй байна.
8. Сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сумд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлсэн, 4 сумын хяналтын зөвлөл сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
9. Зээлийн мэдээллийн санд Тэс сум 2024 онд 8 зээлдэгчийн 2.7 сая төгрөг, 2025 онд 21 зээлдэгчийн 21.3 сая төгрөг, нийт 24.0 сая төгрөгийн 29 зээлдэгчийн мэдээллийг зөрүүтэй оруулсан байна.
10. Зүүнговь сумын Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авч төлөлт хийгээгүй 1 зээлдэгчээс Шүүхийн шийдвэрээр 129 боодол өвс, 1 зээлдэгчээс 325 боодол өвсийг хураан авсан ч, худалдан борлуулж сангийн дансанд төвлөрүүлээгүй тул зээлийн өрийн үлдэгдлээс хасагдаагүй байна.
11. Сагил сум төсөл хүлээн авахдаа журамд заасан хугацааг баримтлаагүйгээс төсөлд хамрагдах боломжит хугацаа хязгаарлагдаж 2024-2025 онд Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгоогүй байна.
12. Тэс, Завхан, Наранбулаг, Хяргас сум зээл авсан Хоршооны нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжих байршил, сонгон шалгаруулсан шийдвэрийн мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлээгүй нь мэдээллийн ил тод байдал алдагдах, иргэд үнэн зөв мэдээллээр хангагдах боломжийг алдагдуулсан байна.

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛС
УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас: 7045-2315 Факс: 7045-4095

Цахим шуудан: info@uvs.gov.mn

Цахим хуудас: www.uvs.gov.mn

2026.07.02 № 1/1332
танай _____ -ны № _____ -т

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Өөрчлөлт оруулах санал байхгүй болно.



Э.НАСАНБАТ

disk: AZDTG-zasag-5
8326060513



УВС АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
5 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85169
Утас: 7045-3433, Факс:
Цахим шуудан: hhaag@uv.mofa.gov.mn
Цахим хуудас: uv-hhaag.opengov.mn

2026.07.03 № 1/194

танай _____-ны № _____-т

Г УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ 7

Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа үр дүн, үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Нэмэлт санал байхгүй болно.



Увс аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар
Захиргаа
Дарга
Цэнд Цэвээнравдан
2026-07-03 09:05:36



УВС АЙМАГ
УЛААНГОМ СУМЫН
ЗАСАГ ДАРГА

Улаангом, Увс аймаг, 85160

Утас: 7045-2023

Цахим шуудан: admin@ulaangom.uv.gov.mn

Цахим хуудас: uvs.gov.mn/ulaangomsum

2026.07.02 № 273

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа үр дүн, үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төсөлтэй холбоотой хүргүүлэх санал хүсэлт байхгүй болно.

ЗАСАГ ДАРГА



Ц. ГАНТӨМӨР

8516070311
D:\УСЗДТГ\45.docx



**УВС АЙМАГ
ТЭС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР**

Тооромт, Тэс сум, Увс аймаг, 85060

Цахим шуудан: admin@tes.uv.gov.mn

Цахим хуудас: uvs.gov.mn/tessum

2026.07.02 № 32

танай _____ -ны № _____ -т

**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Хоршоо хөгжүүлэх сангийн 2024-2025 оны үйл
ажиллагаанд хийсэн аудитын тайлантай санал
нийлж байна.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ЦЭРЭНЖАВ



**Холбогдох байгууллагын ирүүлсэн
саналд өгөх тайлбар**

Хоршоо хөгжүүлэх сангийн үр дүн, үр нөлөөд хийсэн аудитын тайлангийн төсөлд:

Аймгийн сумын Засаг дарга 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 1/1332 дугаар албан бичгээр “Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа үр дүн, үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Өөрчлөлт оруулах санал х байхгүй болно” гэсэн хариу ирүүлсэн тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Хүнс, хөдөө аж ахуйн газар 2026 оны 07 дугаар сарын 3-ны өдрийн 1/194 дүгээр албан бичгээр “Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа үр дүн, үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Нэмэлт санал байхгүй болно” гэсэн хариу ирүүлсэн тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Улаангом сумын Засаг дарга 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 273 дугаар албан бичгээр “Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа үр дүн, үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Төсөлтэй холбоотой хүргүүлэх санал хүсэлт байхгүй болно” гэсэн хариу ирүүлсэн тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Тэс сумын Засаг даргын тамгын газар 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 32 дугаар албан бичгээр “Хоршоо хөгжүүлэх сангийн 2024-2025 оны үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлантай санал нийлж байна” гэсэн хариу ирүүлсэн тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

Сумдын Засаг дарга нарт:

1. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлүүдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, Монгол банкны зээлийн мэдээллийн санд мэдээллийг нийлүүлэх зэрэг арга замаар барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Тэс, Завхан сумын Засаг дарга нарт:

2. Журамд заасан шалгуур, шаардлагыг бүрэн хангасан төсөлд зээл олгож байх.

Тэс, Түргэн, Тариалан, Малчин сумын Засаг дарга нарт:

3. Зээл авсан хоршоодын барьцаа хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлж барьцаалбар үйлдүүлэх.

Өлгий, Өндөрхангай, Хяргас сумын Засаг дарга нарт:

4. Авсан зээлээ зориулалтын дагуу зарцуулаагүй зээлдэгчид журамд заасан холбогдох арга хэмжээг авах.

Тэс, Бөхмөрөн, Давст сумын Засаг дарга нарт:

5. Хүүгийн орлогыг журамд заасан зарцуулах хувь хэмжээнээс хэтрүүлэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахгүй байх.

Наранбулаг, Өлгий сумын Засаг дарга нарт:

6. Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнах.

Зүүнговь сумын Засаг даргад:

7. Хоёр зээлдэгчийн зээлийн үлдэгдэл зөрүүтэй байгаа асуудлыг шийдвэрлэх.

Тэс сумын Засаг даргад:

8. Зээлдэгч нарын мэдээллийг зээлийн мэдээллийн санд үнэн зөвөөр оруулж үүссэн зөрчлийг арилгах.

Сагил сумын Засаг даргад:

9. Төсөл хүлээн авахдаа журамд заасан хугацааг баримталж ажиллах

Бөхмөрөн, Тариалан, Цагаанхайрхан, Ховд сумын Засаг дарга нарт:

10. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах.

Тэс, Завхан, Наранбулаг, Хяргас сумын Засаг дарга нарт:

11. Зээл авсан Хоршооны нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжих байршил, сонгон шалгаруулсан шийдвэрийн мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлж ажиллах.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

/ М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



/ Б.АВИРМЭД /

/ Р.АЮУШ /

/ А.НАНЖИДМАА /

/ Л.ШАГДАРСҮРЭН /

Хавсралт-1

Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үлдэгдлийг 2024 оны байдлаар өссөн дүнгээр

/төгрөгөөр/

Д/Д	Сумын нэр	Анх олгосон зээлийн хэмжээ	Зээлийн үлдэгдэл	Зээлийн тоо	Зээлийн ангилал									
					Хэвийн		Хугацаа хэтэрсэн		Хэвийн бус		Эргэлзээтэй		Муу	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зүүнхангай сум	177,000,000.0	161,647,715.0	12	0	-	1	26,875,308.0	0	-	2	37,911,586.0	9	96,860,821.0
2	Баруунтуруун сум	230,500,000.0	169,037,255.0	8	4	100,053,271.0	2	24,968,575.0	1	43,642,116.0	0	-	1	373,292.0
3	Өндөрхангай сум	215,000,000.0	172,060,231.0	9	5	74,299,042.0	1	10,542,287.0	0	-	1	51,893,872.0	2	35,325,030.0
4	Зүүнговь сум	211,055,000.0	123,698,248.0	14	4	4,303,590.0	1	34,289,510.0	0	-	2	53,882,984.0	7	31,222,165.0
5	Цагаанхайрхан сум	135,000,000.0	103,898,140.0	8	5	63,184,959.0	1	17,102,258.0	2	23,610,923.0	0	-	0	-
6	Тэс сум	301,500,000.0	282,173,224.0	48	7	99,424,286.0	3	12,822,519.0	9	38,387,461.0	8	47,559,351.0	21	83,979,607.0
7	Хяргас сум	238,000,000.0	222,084,101.0	12	6	140,362,190.0	0	-	0	-	0	-	6	81,721,911.0
8	Малчин сум	181,290,000.0	161,899,326.0	5	1	14,247,004.0	1	28,581,645.0	1	54,564,552.0	2	64,506,125.0	0	-
9	Завхан сум	197,000,000.0	131,181,211.0	9	3	61,758,251.0	1	22,323,216.0	0	-	0	-	5	47,099,744.0
10	Наранбулаг сум	215,000,000.0	152,114,134.0	12	6	62,237,372.0	2	28,259,405.0	0	-	3	56,817,357.0	1	4,800,000.0
11	Давст сум	162,000,000.0	132,014,500.0	6	3	62,894,505.0	1	45,440,095.0	0	-	0	-	2	23,679,900.0
12	Тариалан сум	298,400,000.0	210,190,001.0	10	7	170,712,433.0	0	-	0	-	0	-	3	39,477,568.0
13	Өлгий сум	148,375,000.0	123,265,741.0	13	6	59,559,464.0	0	-	0	-	0	-	7	63,706,277.0
14	Улаангом сум	971,994,195.0	764,228,500.0	86	17	216,877,391.0	3	13,144,731.0	9	118,226,071.0	4	64,555,567.0	53	351,424,739.0
15	Сагил сум	145,300,000.0	75,700,722.0	12	3	41,137,238.0	0	-	0	-	0	-	9	34,563,484.0
16	Түргэн сум	188,000,000.0	150,065,999.0	17	15	141,846,178.0	0	-	0	-	0	-	2	8,219,821.0
17	Өмнөговь сум	348,800,000.0	179,025,106.0	33	10	116,997,267.0	1	8,708,117.0	1	2,199,976.0	2	4,354,657.0	19	46,765,089.0
18	Бөхмөрөн сум	162,500,000.0	147,938,491.0	11	0	-	0	-	1	23,571,285.0	2	51,791,199.0	8	72,576,007.0
19	Ховд сум	63,923,000.0	58,739,550.0	4	2	48,046,999.0	0	-	0	-	0	-	2	10,692,551.0
Аймгийн дүн		4,590,637,195.0	3,520,962,195.0	3 29	1 04	1,477,941,439.0	18	273,057,666.0	24	304,202,385.0	26	433,272,698.0	1 57	1,032,488,007.0

Эх сурвалж: ХХААГ, сумдаас ирүүлсэн судалгаа

Хавсралт-2

Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үлдэгдлийг 2024 оны байдлаар өссөн дүнгээр

/төгрөгөөр/

Д/Д	Сумын нэр	Анх олгосон зээлийн хэмжээ	Зээлийн үлдэгдэл	Зээлийн тоо	Зээлийн ангилал									
					Хэвийн		Хугацаа хэтэрсэн		Хэвийн бус		Эргэлзээтэй		Муу	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зүүнхангай сум	174,000,000.0	126,708,939.0	11	0	-	1	22,126,780.0	0	-	1	14,811,189.0	9	89,770,970.0
2	Баруунтуруун сум	185,500,000.0	109,051,015.0	6	3	65,858,562.0	0	-	0	-	0	-	3	43,192,452.0
3	Өндөрхангай сум	235,000,000.0	179,527,945.0	7	4	98,926,043.0	0	-	0	-	0	-	3	80,601,902.0
4	Зүүнговь сум	199,255,000.0	86,013,774.0	13	4	194,064.0	0	-	0	-	1	3,028,489.0	8	82,791,222.0
5	Цагаанхайрхан сум	230,000,000.0	182,513,026.0	8	4	142,436,158.0	2	18,643,622.0	2	21,433,246.0	0	-	0	-
6	Тэс сум	289,000,000.0	239,485,743.0	43	12	67,689,982.0	1	2,917,509.0	5	75,899,330.0	2	18,310,424.0	23	74,668,498.0
7	Хяргас сум	268,000,000.0	221,503,158.0	12	5	122,858,070.0	2	44,023,177.0	0	-	0	-	5	54,621,911.0
8	Малчин сум	195,290,000.0	153,129,270.0	6	2	25,076,413.0	0	-	0	-	0	-	4	128,052,857.0
9	Завхан сум	242,000,000.0	151,289,106.0	9	3	68,767,838.0	1	28,836,808.0	0	-	1	17,025,216.0	4	36,659,244.0
10	Наранбулаг сум	214,000,000.0	124,022,838.0	11	5	57,588,504.0	0	-	0	-	1	12,227,775.0	5	54,206,559.0
11	Давст сум	147,000,000.0	75,701,000.0	5	4	67,321,100.0	0	-	0	-	0	-	1	8,379,900.0
12	Тариалан сум	254,000,000.0	196,779,890.0	7	5	192,275,011.0	0	-	0	-	0	-	2	4,504,879.0
13	Өлгий сум	129,075,000.0	78,654,646.0	10	2	8,046,996.0	3	33,034,142.0	0	-	0	-	5	37,573,507.0
14	Улаангом сум	882,500,000.0	597,164,298.0	70	12	154,569,836.0	5	48,445,017.0	0	-	6	78,566,651.0	47	315,582,794.0
15	Сагил сум	124,000,000.0	55,670,902.0	10	2	6,155,124.0	0	-	0	-	1	31,578,081.0	7	17,937,697.0
16	Түргэн сум	192,000,000.0	110,457,236.0	16	14	94,052,083.0	1	11,031,678.0	0	-	0	-	1	5,373,475.0
17	Өмнөговь сум	222,800,000.0	115,055,778.0	19	5	64,903,870.0	1	6,908,117.0	0	-	2	10,314,732.0	11	32,929,059.0
18	Бөхмөрөн сум	142,500,000.0	126,637,903.0	9	0	-	0	-	0	-	0	-	9	126,637,903.0
19	Ховд сум	236,997,400.0	230,596,181.0	8	6	219,903,630.0	0	-	0	-	0	-	2	10,692,551.0
Аймгийн дүн		4,562,917,400.0	3,159,962,649.0	2 80	92	1,456,623,284.0	17	215,966,850.0	7	97,332,576.0	15	185,862,557.0	1 49	1,204,177,381.0

Эх сурвалж: ХХААГ, сумдаас ирүүлсэн судалгаа